



Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

Улаанбаатар хот-14251, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, 5-р хороолол 10Б байр, Бизнес тауэр, 20
давхар

Утасны дугаар: +(976) 7577-0002

info@mongolianre.com

www.mongolianre.com

ЖИЛИЙН
ТАЙЛАН
2021



2021

ИТГЭЛ
ДҮҮРЭН
ИРЭЭДҮЙ

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

Бидний тухай

Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм.

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж, дотоодын 20 даатгагч болон даатгалын зуучлагч, 7 банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлээр 13 олон улсын давхар даатгагч болон экспортын зээлийн даатгагч, олон улсын мэргэжлийн холбоод, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Байгуулагдсан он:

2014

Хамтран ажиллагч:

20

даатгагч,
даатгалын зуучлагч

7

банк,
санхүүгийн байгууллага

13

олон улсын давхар даатгагч,
экспортын зээлийн даатгагч,
олон улсын мэргэжлийн холбоод,
банк, санхүүгийн байгууллага.



Б.Жавхлант

Гүйцэтгэх захирал



Эрхэм хүндэт түншүүд, харилцагчид, даатгуулагчид, мэргэжил нэгтнүүд та бүхэндээ удирдлагын багийн нэрийн өмнөөс болон хувиасаа энэ өдрийн мэнд хүргэн мэндчилж байна!

Өнгөрч буй 2021 онд Ковид19-ийн нөхцөл байдал улам бүр хүндэрч, дэлхий нийтээрээ томоохон сорилттой тулгарсан жил болж өнгөрлөө. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас цар тахал гэж зарласан энэ хүнд үед дэлхийн олон орны засгийн газар нэн тэргүүнд иргэдийнхээ аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засаг, нийгмийн хатуу бодлого барьж ажилласан явдал нь бидний амьдралд төдийгүй дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт, нөлөө үзүүлж байгааг бид харж байна.

Юуны өмнө манай компанийг энэ хүнд үеийг даван туулахад бидэнтэй хамт байж, хамтран зүтгэсэн та бүхэнд компанийн хамт олны нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна. Цар тахлын аюул ард хоцорсон ч түүний дараах эдийн засгийн онцгой нөхцөл орчинд дасан зохицож, эдийн засгийн хүндрэлтэй үеийг хамтын хүчээр давна гэдэгтэй манай хамт олон итгэлтэй байна.

Урд хожид болж байгаагүй дэлхий нийтийг хамарсан гамшгийн эрсдэлийн цаг мөчид даатгуулагч, харилцагчдынхаа өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлж, нийгэм, эдийн засгийн мөчлөгийг хохирол багатайгаар даван туулахад даатгалын салбар өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй. Цар тахлын эсрэг авч буй арга хэмжээтэй холбогдсон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврууд, түүнийг дагасан шинэ төрлийн эрсдэлүүд иргэд болон бизнесийн байгууллагуудад өөрсдийн ажил амьдрал, бизнест урьдчилан тодорхойлох боломжгүй нөхцөл орчныг үүсгэж байгаа хүндхэн мөчид бидний зорилго, үнэт зүйлс, хүргэж буй давхар даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ нь зах зээлийн эрэлтэд тулгуурласан, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн цогц, шинэлэг, мэргэжлийн үйл ажиллагаа байх болно.

Монгол Улсын цорын ганц давхар даатгагч болохын хувьд Үндэсний давхар даатгал ХК нь санхүүгийн чадавх, гадаад хамтын ажиллагааны давуу тал, чадварлаг хүний нөөцөд тулгуурласан, зах зээлийн орчиндоо зохицсон орчин үеийн, мэргэжлийн давхар даатгалын үйлчилгээг үзүүлэхийг зорьж байна. Бид дэлхийн хэмжээнд туршлагатай, нэр хүндтэй давхар даатгагчид, брокеруудтай хамтран ажиллаж, эрсдэлээ хуваалцаж, эрсдэл даах чадвараа нэмэгдүүлж, харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхыг ханган ажиллаж байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд манай компани нээлттэй хувьцаат компани болох зорилт дэвшүүлэн, түүний бэлтгэл ажлыг эхлүүлж, цаашдаа Үндэсний давхар даатгалын сонгодог тогтолцоог бий болгохоор ажиллаж байгааг дурдахад таатай байна. Бид хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлсэн, үйлчлүүлэгчид, харилцагчиддаа ойр, төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрхэмлэсэн, ил тод, нээлттэй мэргэжлийн давхар даатгалын компани болохоор зорин ажиллаж байна.


Эрхэм даатгуулагчид, харилцагчид, хувьцаа эзэмшигч болон стратегийн түншүүддээ Үндэсний давхар даатгал ХК-ийн хамт олны нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

Б. Жавхлант



Эрхэм зорилго

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.

Алсын хараа

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.

Үнэт зүйлс

Мэргэшсэн өндөр чадавх

Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин.

Манлайлал

Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлсэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

Хамтын зүтгэл

Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Үнэнч шударга зарчим


Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

Ил тод харилцаа холбоо

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

Компанийн бүтэц

Үндэсний давхар даатгал ХК нь Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Комплаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг



Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

З.Энхболд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Сангийн яамны хууль эрх зүйн газрын дарга

Ч.Тавинжил

Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга

Ц.Болорчулуун

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлого төлөвлөлтийн газрын дарга

А.Дэмбэрэл

Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

П.Эрдэнэбаатар

Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга

Д.Насанжаргал

Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Б.Шаравсамбуу

Хараат бус гишүүн

Ц.Түмэнхишиг

Хараат бус гишүүн

Я. Батханд

Хараат бус гишүүн

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд



Тайлант онд компанийн хөрөнгө өмнөх оноос 4.68 хувь буюу 2 тэрбум 12 сая төгрөгөөр өсч 57 тэрбум 826 сая төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын 14 хувийг эзэлж байна.

Давхар даатгалын хураамж




Давхар даатгалын хураамжийг өнгөрсөн жилээс 20 хувь буюу 673 сая төгрөгөөр нэмэгдүүлж 4 тэрбум 153 сая төгрөгийг хуримтлууллаа.


Компанийн нийт орлого ба цэвэр ашиг



Төлбөрийн чадварын харьцаа




Хохирлын харьцаа




Компанийн ашгийн үзүүлэлт буурсан нь компани үйл ажиллагаагаа өргөжүүлж 12 даатгалын хэлбэрээр давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын хэлбэр бүрээр нөөц сан үүсгэсэн, мөн банкны хадгаламжийн хүү буурсанаар компанийн хөрөнгө оруулалтаас орж ирэх орлого буурсантай холбоотой. Нөөц сангийн зардал нь компанийн шууд зардал биш бөгөөд сангийн хэмжээ их байх тусам компанийн эрсдэл даах чадвар ихэснэ.

Компанийн нийт нөөц сангийн хэмжээ 500 гаруй сая төгрөгөөр нэмэгдэж 25 тэрбум 739 сая төгрөгт хүрч их хэмжээний эрсдэлийг даах чадвартай боллоо.

Нөөц сан /тэрбум төгрөг/



2021 оны нөөц сангийн хэмжээ



Онцлох үйл явдал

■ Азийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор байгуулагдсан Азийн баталгаа, зээлийн даатгалын холбоонд гишүүн байгууллагаар элслээ.

■ Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүллээ. Анхлан даатгагчаар Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК ажиллах юм.


■ Үндэсний давхар даатгал ХК нь 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан даатгалын хэлбэрүүд болох хөдөө аж ахуйн даатгалууд, гэнэтийн осол, хөрөнгө, ачаа тээвэр, хариуцлага, санхүү, агаарын хөлөг, агаарын хөлгийн хариуцлага, барилга угсралт, тээврийн хэрэгслийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, нийт 4 тэрбум 153 сая төгрөгийн хураамж төвлөрүүлж төлөвлөгөөгөө 21 хувиар давуулан биелүүллээ. Энэ нь Монгол Улсаас олон улсын давхар даатгагч руу шилжүүлж буй нийт давхар даатгалын хураамжийн 6%-ийг эзэлж байна.



2021

Үндсэн үйл ажиллагаа

2021 он ковид-19 цар тахлын тархалт өндөр жил болсон ч манай компани даатгалын хураамжийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж чадлаа. Компанийн даатгалын багцыг харвал хамгийн өндөр 36.6 хувийг малын индексжүүлсэн даатгал, 26.9 хувийг хөрөнгийн даатгал эзэлж байгаа бол санхүүгийн даатгал, агаарын хөлгийн хариуцлагын даатгал бага хувийг эзэлж байна.



Малын индексжүүлсэн даатгалын борлуулалт

	2021	Өмнөх оноос	Өссөн хувь
Даатгалын нийт хураамж	3 тэрбум 922 сая	443 сая	12.7%
Даатгуулсан малчин өрх	34709	6182	21.6%
Давхар даатгалын орлого	1 тэрбум 319 сая	211 сая	19%



2021

7.4 сая тоо толгой

2021 оны МИД-ын борлуулалтад Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, Миг даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК зэрэг даатгалын компаниуд болон зуучлалаар Төрийн банк, Хаан банк оролцон 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд нийт малчин өрхийн 19 хувийг даатгасан.

4.73%

0.29%

6.73%

51.01%

37.24%

МИД хэрэгжсэн 16 жилийн хугацаанд давхардсан тоогоор 266 мянга орчим малчин өрхийн 56.2 сая толгой малыг даатгалд хамруулж, 27.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 45,849 малчин өрх нийт 8.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид амьдрал дээр бодитойгоор хүртээд байна.

Эрсдэл даах чадвар
13 тэрбум 828 сая

769 сая
ОУДД –
3 тэрбум 382 сая

Дээд түвшний эрсдэлийн сан

2 тэрбум 961 сая
ОУДД –
4 тэрбум 950 сая

Дунд түвшний эрсдэлийн сан

1 тэрбум 765 сая

Хамтын эрсдэлийн сан

Давхар даатгалын багц гэрээ


Ердийн даатгалын компаниудтай хөрөнгө, барилга угсралт, хариуцлага, ачаа тээвэр, автотээврийн хэрэгслийн, санхүүгийн даатгалын хамгаалалт бүхий трити гэрээнүүдийг байгууллаа.



Дахин давхар даатгал

■ Хөрөнгө, барилга угсралт, хариуцлага, ачаа тээвэр, гэнэтийн осол, тусгай зориулалтын болон хүнд машин механизмын даатгал дээр Жи Би Бода давхар даатгалын зуучлагчаар дамжуулан олон улсын нэр хүнд бүхий давхар даатгагч нар /СКОР 45%, ХАННОВЭР РЭ 30%, ОДИССЭЙ РЭ 20%, ТАЙПИН РЭ 5%-т харилцан тохиролцсон хэмжээгээр дахин давхар даатгалын Трити гэрээг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс давхар даатгалын хамгаалалтын хугацааг эхлүүлэн байгуулсан.

■ Тэргүүлэгч давхар даатгагч СКОР компанийн үнэлгээ S&P and Fitch компаниас AA-, Moody's компаниас AA3 гэж үнэлсэн байна.



SCOR
The Art & Science of Risk

ODYSSEYRE

hannover re

中国太平
CHINA TAIPING
中國太平保險(香港)有限公司
China Taiping Insurance (HK) Company Limited

Хууль, эрх зүйн орчныг сайжруулах

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж, хуулийн төсөл, үзэл баримтлалд саналаа өгч ажиллаж байна. Хуулийн төсөл батлагдсанаар валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын эрсдэлийг нэгдсэн журмаар олон улсад гаргаж, зардлыг бууруулах, дотоодын давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгох ач холбогдолтой.

ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ


ХХААХҮЯ, тариалангийн даатгалын олон улсын зөвлөлтэй хамтран үрийн тариалангийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, үр тариа, бусад таримлын тариаланг даатгах эрх зүйн орчныг бүрдүүлснээр газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, нэмэгдүүлэх боломж бүрдэх юм

ГАМШГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” Техник туслалцааны төсөл ОБЕГ-т хэрэгжиж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль боловсруулах ба тус хуулийн зөвлөх багт Үндэсний давхар даатгал ХК-аас төлөөлөл орон ажиллаж байна.

Нийт нөхөн төлбөр

■ Малын индексжүүлсэн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгалд нөхөн төлбөр гарсан ба нийт 1,047.0 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.



Малын индексжүүлсэн даатгал

■ Малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Төв, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн 9,446 малчин өрхөд нийт 2.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр өгснөөс Үндэсний давхар даатгал ХК 652.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг малчид, иргэдэд олголоо.

583.1
сая

1.346.0
сая

462.1
сая

188.2
сая

14
сая



Нийгмийн хариуцлага

■ Ковид-19 цар тахлын үеэр ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалж, компанийн бизнесийг хэвийн явуулах бүхий л боломжит арга хэмжээг авч ажилласан. Компанийн хувьд ажилтнууд, бизнесийн хамтрагч байгууллагуудыг хамгаалах нь тэргүүний зорилт бөгөөд цар тахлын эсрэг хурдан, зохион байгуулалттайгаар хариу үйлдэл үзүүлэн ажиллалаа.

■ Үндэсний давхар даатгал ХК болон МИД-д оролцогч даатгалын компаниудын зүгээс даатгуулагч малчдад тусламж үзүүлэх зорилгоор зудын гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд зудын өндөр эрсдэлтэй, хаваржилт хүндэрч болзошгүй Архангай, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай зэрэг 6 аймгийн 81 сумдад 2017 оноос хойш мал сүргээ даатгуулсан нийт 1,630 малчдад өвс тэжээл, бараа материалын тусламжийг олголоо. Малчдад олгосон төлийн уут, хөвөнтэй бээлийг Монголын пара триатлоны холбоо НҮТББ-ын тусгай хэрэгцээт иргэд хийсэн юм.

■ Нийслэлийн БЗД-ийн 12 хүртэлх насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах эмчилгээ хийх, сургуулийн өмнөх боловсрол эзэмшихэд нь бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборт 3 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлэв.

Аудитын тайлан

Дүгнэлт

Бид "Үндэсний Давхар даатгал" ХК (цаашид "компани" гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул "Үндэсний давхар даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	592,542	694,366
Даатгалын авлага	607,285	869,051
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлага	36,434	56,393
Бараа материал	5,789	-
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	345,003	494,640
Хөрөнгө оруулалт	55,444,887	52,002,143
Эргэлтийн хөрөнгийн дүн	57,031,940	54,116,593
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	390,448	610,754
Биет бус хөрөнгө	422,133	511,468
Хойшлогдсон татварын хөрөнгө	4	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	812,585	1,122,222
Нийт хөрөнгө	57,844,525	55,238,815
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	-	21,727
Бусад санхүүгийн өр төлбөр	98,665	280,190
Бусад санхүүгийн бус өр төлбөр	2,142	136
Хойшлогдсон татварын өр	16,896	6,146
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	1,740,147	1,195,141
Хамтын эрсдэлийн сан	1,764,888	1,927,143
Эрсдэлээс хамгаалах сан	4,975,605	4,453,631
Өр төлбөрийн нийт дүн	8,598,343	7,884,114
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	24,500,000	24,500,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Хуримтлагдсан ашиг	5,256,918	3,365,437
Эздийн өмчийн дүн	49,246,182	47,354,701
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	57,844,525	55,238,815

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2021	2020
Даатгалын хураамжийн нийт орлого	4,153,339	3,572,022
Даатгалын хураамжийн буцаалт	(74,478)	(540)
Давхар даатгалын хураамжийн зардал	(1,767,432)	(1,858,926)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	2,311,429	1,712,556
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(545,007)	(268,531)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(149,637)	(545,108)
Орлогод тооцсон хураамж	1,616,785	898,917
Нийт нөхөн төлбөрийн зардал	(1,046,661)	-
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	420,674	-
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	9,794	-
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(521,974)	(777,075)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(1,138,167)	(777,075)
Хөрөнгө оруулалтын орлого	5,353,090	6,208,700
Бусад даатгалын хураамжийн бус орлого	125	82,037
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,609,564)	(2,588,710)
Санхүүгийн зардал	(15,043)	(32,632)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(430,297)	33,228
Татвар төлөхийн өмнөх ашиг	2,776,929	3,824,465
Орлогын татварын зардал	(546,055)	(627,016)
Тайлант үеийн цэвэр ашиг	2,230,874	3,197,449